

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

24/06

“Хорин хоёрдугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлыг хойшлуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 болон 69.6 дахь заалт
Компанийн Дүрмийн 7.8.4 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024.11.29-ний өдөр товлогдсон ээлжит бус
хурлын ирц хүрээгүйн улмаас хойшлуулж, 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
14:00 цагт Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод
хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн дор
дурдсан асуудлыг хойшлуулсан хурлаар өөрчлөлгүйгээр хэлэлцсүгэй:
 - а. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх
газар болон үл хөдлөх эд хөрөнгө худалдахтай холбоотой их хэмжээний
хэлцэл байгуулахыг дэмжих эсэх асуудлаар зөвшөөрөл олгох, их хэмжээний
гэрээ байгуулах эрх олгох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа
эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 19-ний
өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хойшлуулсан ээлжит бус хурлын тухай зарыг 2024 оны 12
дугаар сарын 4-ний өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр,
2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн
биржийн сайтад тавих, брокерийн компанид 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр
хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга
/Б.Эрдэнэбаяр/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх
бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-уудаас авч
танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа
эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах
“саналын хуудас”-ын агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах
эцсийн хугацааг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагаар тасалбар
болгосугай.
9. Тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хурал зохион
байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
 - Б.Мөнгэрэл дарга
 - М.Нэргүй гишүүн
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах
шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн
хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р Бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Эрдэнэбаяр/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА